

Корона19 нийгмийн харилцаанаас зай барих арга хэмжээг 1р шат руу шилжүүлэн хэрэгжүүлэх (10.12ны өдрөөс эхлэнэ)

- Эрсдэл өндөрт орох олон нийт ихээр цугладаг газар халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх журмыг чандлан сахих -

Зай барих арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө

1. Уулзалт-цуглаан-арга хэмжээ

(нийслэл орчмын газар нутаг) танхимд 50хүн, гадаа 100хүнээс дээш хэтрэхгүй байх (үзэсгэлэн, яармаг худалдаа, баяр наадам, шоу концерт, эрдэм шинжилгээний хурал нь 4м² тутамд 1хүн) (хөдөө орон нутаг) зөвшөөрөх

(үзэсгэлэн, яармаг худалдаа, баяр наадам, шоу концерт 4м² тутамд 1хүн)

2. Эрсдэл өндөртэй байгууламж (11төрлийн байгууламж*)

(бүх орон нутаг) өөрий биеэр очиж худалдаа хийх зэрэг биечлэн арилжаа наймааны сурталчилгаа хийх газар олноор цуглахыг хориглох, 11төрлийн байгууламжинд халдварт өвчнөөс сэргийлэх журмыг үүрэгт ажил болгох

* клуб зэрэг зугаа цэнгээний газар, ахмад настны дискотек(collatek), бар цэнгээний газар, уушын газар, Hunting rocha, кароке, худалдааны бараа борлуулалт, түгээлтийн төв, урлагийн тоглолтын танхим, хэсэг бүлгээрээ спортын дасгал хийх, сургалт дамжаа(300хүнээс дээш), буфет

3. Олон нийт ихээр цугладаг байгууламж(16төрлийн байгууламж)

(нийслэл орчмын газар нутаг) гуанз, кафе зэрэг эрсдэл өндөр 16төрлийн байгууламжинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх журмыг үүрэгт ажил болгох (хөдөө орон нутаг) өдөр тутмын амьдралд зай барих арга хэмжээг хэрэгжүүлэхийг уриалах

4. Спортын арга хэмжээ

(бүх орон нутаг) үзэгчийн тоог хязгаарлах(дээд тал нь 30%)

5. Улсын нийтийн байгууламж

(бүх орон нутаг) үйл ажиллагаа явуулах боломжтой, хүний тоог хязгаарлах(дээд тал нь 50%)

6. Сүм

(нийслэл орчимын газар нутаг) Сүмд мөргөл залбирал үйлдэх боломжтой ч хүний тоог хязгаарлах, цуглах · хооллохыг хориглоно.

(нийслэл орчмын бус газар нутаг) бүс нутгийн байдлыг харгалзан хэрэгжүүлэх

7. Нийгмийн халамжийн байгууллага, хүүхдийн цэцэрлэг

(бүх орон нутаг) үйл ажиллагаа явуулах боломжтой(халдварт өвчнөөс сэргийлэх дэглэмийг нарийн дагаж мөрдөх)

8. Албан байгууллага · аж ахуйн нэгж

(бүх орон нутаг) олон нийтийн байгууллага: уян хатан нөхцөлөөр-гэрээс ажиллах зэрэг ажиллах хүчний нягтралыг бууруулах (нийт ажилтны 1/3)

Төрийн бус байгууллага : уян хатан нөхцөлөөр-гэрээс ажиллахыг идэвхжүүлэн уриалах